



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/12/СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2021 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын дөрөвдүгээр газрын захирал,
тэргүүлэх аудитор: Я.Самбууням
Утас: 260949
Цахим хаяг: Sambuunyamy@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628
Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Нарангэрэл
Утас: 260512
Цахим хаяг: Narangerelba@audit.gov.mn

Аудитор: Д.Эрдэнэчимэг
Утас: 260512
Цахим хаяг: erdenechimegda@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнхцацрал
Утас: 260512
Цахим хаяг: munkhtsatsrall@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	13
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	13
3.5.3 Авлага	13
3.5.6 Бараа материал.....	14
3.5.7 Үндсэн хөрөнгө	15
3.5.8 Өр төлбөр	15
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Шилэн дансны мэдээлэл.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
Залруулсан алдаа.....	19
4.2.1 Албан шаардлага	19
4.2.2 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
ИХАШШТГ	Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСННББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭХАШШТГ	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.04.26 № 1329

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A square red stamp containing a handwritten signature in black ink. The signature is stylized and appears to read 'Д.ЗАНДАНБАТ'. The stamp has a decorative border and some faint text inside.

Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны дугаар	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,155,995.0	1,405,548.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	0.0	0.0
32	Богино хугацаат хөрөнгө оруулалт	0.0	0.0
33	Авлага	5,814.7	18,758.7
34	Урьдчилгаа	0.0	0.0
35	Бараа материал	1,150,180.3	1,386,789.3
39	Үндсэн хөрөнгө	48,021,736.8	48,867,981.8
39200	Биет хөрөнгө	43,300,910.3	44,017,780.5
39300	Биет бус хөрөнгө	4,720,826.5	4,850,201.3
3	Нийт хөрөнгийн дүн	49,177,731.8	50,273,529.8
4	Нийт өр төлбөр	913.8	441.6
41	Богино хугацаат өр төлбөр	913.8	441.6
41300	Өглөг	913.8	441.6
42	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.0	0.0
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	49,176,818.0	50,273,088.2
51	Засгийн газрын хувь оролцоо	49,176,818.0	50,273,088.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,737,292.1	21,787,297.2
51200	Хуримтлагдсан үр дүн	14,134,677.6	15,215,705.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,304,848.3	13,270,086.0
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	49,177,731.8	50,273,529.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны дугаар	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	51,535,331.5	58,112,426.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	155,506.2	1,690,536.5
120	Нийтлэг татварын бус орлого	147,134.4	1,657,819.7
122	Тусламжийн орлого	8,371.8	32,716.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	51,379,825.3	56,421,890.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	52,825,949.9	57,050,403.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52,825,949.9	57,050,403.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,715,649.2	53,361,589.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,793,844.6	38,584,588.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,498,882.8	4,988,640.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,620,561.4	1,808,054.1
2104	Хангамж, бараа материалын зардал	2,804,724.5	3,036,985.5
2105	Норматив зардал	26,190.8	27,814.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	858,755.2	941,360.9
2107	Томилолт, зочны зардал	347,197.1	222,933.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,164,252.0	1,028,743.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,601,240.8	2,722,468.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,110,300.7	3,688,813.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(1,290,618.4)	1,062,023.7
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,691.9	15,758.5
VI	НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(1,293,310.3)	1,046,265.2

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Д/д	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	50,467,557.6		50,467,557.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	12,230.7		12,230.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,479,788.4		50,479,788.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(9,660.1)		(9,660.1)
5	Тайлант үеийн үр дүн	(1,293,310.2)		(1,293,310.2)
6	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	49,176,818.0		49,176,818.0
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	24,489.0		24,489.0
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	49,201,307.0		49,201,307.0
9	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(24,489.0)		(24,489.0)
10	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	50,005.0		50,005.0
11	Тайлант үеийн үр дүн	1,046,265.2		1,046,265.2
12	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	50,273,088.3		50,273,088.3

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны дугаар	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	51,458,838.2	56,697,654.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,734.4	275,666.3
120	Нийтлэг татварын бус орлого	78,734.4	275,666.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	51,380,103.8	56,421,988.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,121,721.1	55,921,458.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,121,721.1	55,921,458.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,010,687.0	52,217,645.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,779,257.1	38,577,989.6
2102	Ажил олгогч нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,499,281.3	4,993,503.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,622,517.7	1,806,563.9
2104	Хангамж, бараа материалын зардал	2,746,081.0	3,062,017.5
2105	Норматив зардал	40,990.1	41,118.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,401,806.4	2,270,692.4
2107	Томилолт, зочны зардал	362,790.1	228,845.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,170,792.7	1,073,313.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	387,170.6	163,600.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,111,034.1	3,703,813.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,337,117.1	776,195.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,338,215.0	776,195.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,338,215.0	776,195.8
2200	Дотоод эх үүсвэрээр	1,338,215.0	776,195.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,338,215.0)	(776,195.8)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(1,097.9)	0.0
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,097.9	0.0
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны дугаар	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,310,295,700.00	54,748,023,194.75	1,562,272,505.25	97.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,310,295,700.00	54,748,023,194.75	1,562,272,505.25	97.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,151,452,700.00	52,632,518,725.31	1,518,933,974.69	97.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,212,658,700.00	38,569,902,056.78	642,756,643.22	98.4
210101	Үндсэн цалин	31,370,305,600.00	30,332,552,367.78	1,037,753,232.22	96.7
210102	Нэмэгдэл	5,504,230,300.00	5,547,188,661.00	(42,958,361.00)	100.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,508,390,500.00	1,543,744,277.00	(35,353,777.00)	102.3
210104	Урамшуулал	829,732,300.00	1,146,416,751.00	(316,684,451.00)	138.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,300,458,800.00	4,992,492,368.31	307,966,431.69	94.2
210201	Тэтгэврийн даатгал	3,775,604,000.00	3,506,320,740.65	269,283,259.35	92.9
210202	Тэтгэмжийн даатгал	382,565,900.00	373,018,637.73	9,547,262.27	97.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	299,119,100.00	289,159,598.89	9,959,501.11	96.7
210204	Ажилгүйдлийн даатгал	86,392,500.00	89,490,228.05	(3,097,728.05)	103.6
210205	Эрүүл мэндийн даатгал	756,777,300.00	734,503,162.99	22,274,137.01	97.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,892,808,200.00	1,806,563,914.13	86,244,285.87	95.4
210301	Гэрэл, цахилгаан	492,434,000.00	459,262,200.66	33,171,799.34	93.3
210302	Түлш, халаалт	867,186,700.00	821,765,469.26	45,421,230.74	94.8
210303	Цэвэр, бохир ус	138,629,000.00	124,950,279.24	13,678,720.76	90.1
210304	Байрны түрээс	394,558,500.00	400,585,964.97	(6,027,464.97)	101.5
2104	Хангамж, бараа материалын зардал	3,195,452,200.00	3,045,035,076.54	150,417,123.46	95.3
210401	Бичиг хэрэг	1,129,568,400.00	1,111,917,584.00	17,650,816.00	98.4
210402	Тээвэр, шатахуун	738,411,200.00	677,143,117.00	61,268,083.00	91.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	701,947,900.00	644,258,195.54	57,689,704.46	91.8
210404	Ном, хэвлэл	59,025,000.00	53,579,600.00	5,445,400.00	90.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	45,537,400.00	44,030,317.00	1,507,083.00	96.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	520,962,300.00	514,106,263.00	6,856,037.00	98.7
2105	Норматив зардал	41,781,800.00	41,118,793.00	663,007.00	98.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	41,781,800.00	41,118,793.00	663,007.00	98.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,843,427,700.00	2,704,041,899.00	139,385,801.00	95.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,611,981,700.00	1,559,366,975.00	52,614,725.00	96.7
210602	Тавилга	202,600,000.00	177,203,838.00	25,396,162.00	87.5
210604	Урсгал засвар	1,028,846,000.00	967,471,086.00	61,374,914.00	94
2107	Томилолт, зочны зардал	236,909,500.00	213,845,368.00	23,064,132.00	90.3
210702	Дотоод албан томилолт	236,909,500.00	213,845,368.00	23,064,132.00	90.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,276,625,900.00	1,112,918,737.55	163,707,162.45	87.2

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	569,499,900.00	463,717,613.55	105,782,286.45	81.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,292,000.00	13,496,500.00	1,795,500.00	88.3
210803	Даатгалын үйлчилгээ	487,497,900.00	449,898,544.00	37,599,356.00	92.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	12,509,900.00	8,595,474.00	3,914,426.00	68.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	3,300,000.00	2,860,600.00	439,400.00	86.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	171,800,000.00	158,498,500.00	13,301,500.00	92.3
210807	Газрын төлбөр	16,726,200.00	15,851,506.00	874,694.00	94.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	151,329,900.00	146,600,512.00	4,729,388.00	96.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	151,329,900.00	146,600,512.00	4,729,388.00	96.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,158,843,000.00	2,115,504,469.44	43,338,530.56	98
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,158,843,000.00	2,115,504,469.44	43,338,530.56	98
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,200,000.00	9,147,133.00	52,867.00	99.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,881,143,000.00	1,841,795,086.44	39,347,913.56	97.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	268,500,000.00	264,562,250.00	3,937,750.00	98.5
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	56,310,295,700.00	54,748,023,194.75	1,562,272,505.25	97.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	56,190,295,700.00	54,596,296,923.75	1,593,998,776.25	97.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	56,190,295,700.00	54,596,296,923.75	1,593,998,776.25	97.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	120,000,000.00	151,726,271.00	(31,726,271.00)	126.4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000,000.00	151,726,271.00	(31,726,271.00)	126.4
III	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0	0	0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	155	155	0	100
610001	Төсвийн байгууллага	155	155	0	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	1,980	1,947	33	98.3
620001	Удирдах ажилтан	173	168	5	97.1
620002	Гүйцэтгэх ажилтан	1,586	1,524	62	96.1
620003	Үйлчлэх ажилтан	221	255	(34)	115.4

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны дугаар	Тайлангийн үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	437,148,044.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	437,148,044.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,322,384.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,087,580.00
210101	Үндсэн цалин	8,087,580.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,010,949.00
210201	Тэтгэврийн даатгал	1,010,949.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,024,400.00
210401	Бичиг хэрэг	18,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,024,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	246,899,455.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	130,639,755.00
210602	Тавилга	101,268,000.00
210604	Урсгал засвар	14,991,700.00
2107	Томилолт, зочны зардал	15,000,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	15,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,300,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,825,660.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,825,660.00
213305	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	25,825,660.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	437,148,044.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	437,148,044.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,098,529.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	170,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	123,940,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	133,409,515.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлэх, хөрөнгө эзэмших эрх, өр төлбөр төлөх үүргийн хэрэгжилтийг хангах, орлогын бүртгэл, дотоод хяналтыг сайжруулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитор Д.Эрдэнэчимэг, Л.Мөнхцацрал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/314 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн үндсэн чиг үүргийг шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд арга зүй, мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах гэж тодорхойлсон байна. Дээрх чиг үүргээс гадна шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах, шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах, шүүгчийг хуульчдаас шилж сонгох, шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүхийн хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Тайлант онд шүүхийн хөгжлийн стратегийг тодорхойлох, шүүхийн шинэтгэлийн ололтыг бататгах, бэхжүүлэх, хамгаалах, хөгжүүлэх чиглэлд анхаарлаа төвлөрүүлэх, судалгаа мэдээлэл дээр тулгуурлаж бодлого шийдэл гаргах, Шүүхийн тухай багц хуульд үр нөлөөний судалгаа хийж, боловсронгуй болгох, шүүхийг цахимжуулах, шүүхийн үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ТӨБЗГ-ын 2020 оны “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 50 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2020 оны “Төрийн жинхэнэ зарим албан тушаалын цалингийн сүлжээг тогтоох” тухай 75 дугаар тогтоол

Монгол Улсын засгийн газар 2020 онд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай холбоотойгоор дараах тогтоолуудыг гаргаж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай 187;
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 78;
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 114;
- Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай 168;
- Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 183 дугаар тогтоолууд тус тус байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын шинэчлэн боловсруулж мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад нийтээр мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд шинэчлэн баталж, 2020 оны 12 дугаар сарын 01-нээс эхлэн мөрдөж ажилласан байна.

Тус бодлогын баримт бичигт төсвийн гүйцэтгэлийн тайлан, нэмэлт санхүүжилтийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг бэлтгэх заавар, санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэх аргачлалыг шинэчлэн боловсруулж, мөн УСНББОУС-д орсон холбогдох өөрчлөлтүүдийг тусгасан байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудитын тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг ирүүлсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод аудитын газар нь тайлант онд харьяа орон нутаг дахь 9 шүүхийн тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, нийт 52.4 сая төгрөгийн 77 зөрчлийг илрүүлснээс 50.1 сая төгрөгийн 75 алдааг залруулж, 2.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

Дотоод аудитын газраас Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн 2020 оны хэрэгжилтэд хийсэн шалгалтаар байршуулбал зохих 6526 мэдээллээс 6240 мэдээллийг хугацаанд нь, 286 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан гэж дүгнэсэн бөгөөд биелэлт 95.6 хувьтай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 57,066.1 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 1,141.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийг бүрэн төвлөрүүлж, үлдэгдэлгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 243.9 сая төгрөгийн зөрчлийг илрүүлсэн байна. Үүнд:

- Баян-Өлгий аймаг дахь шүүхийн Тамгын газар нь цалингийн зардлаас 15.6 сая төгрөгийг бичиг хэрэг, тээвэр шатахуун, томилолтын зардалд зарцуулсан;
- Булган аймаг дахь шүүхийн Тамгын газар нь сахилгын шийтгэлтэй зарим ажилчдад 2.5 сая төгрөгийн урамшуулал олгосон;
- Тайлант онд Е төлбөрийн баримтгүй нийт 132.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн. /Говь-Алтай аймаг дахь шүүхийн Тамгын газар 25.7 сая, БЗД-ийн ИХАШШТГ 7.4 сая, СХД-ийн ИХАШШТГ 11.7 сая, СБД, ЧД-ийн ИХАШШТГ 42.5 сая, БГД, ХУД, СХД-ийн ЭХАШШТГ 23.4 сая, БЗД, СБД, ЧД-ийн ЭХАШШТГ 21.3 сая төгрөг/
- Дархан-Уул аймаг дахь шүүхийн Тамгын газар нь тушаал шийдвэргүйгээр төрийн үйлчилгээний ажилчдын ур чадварын нэмэгдэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ээлжийн амралтын цалинг давхардуулан нийт 15.3 сая төгрөг олгосон;
- Орхон аймаг дахь шүүхийн Тамгын газар нь анхан шатны баримтын бүрдэлгүй 3.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн;
- БГД, ХУД, СХД-ийн ЭХАШШТГ нь анхан шатны баримтгүй 14.7 сая төгрөгийн зардал гаргасан, шатахууны нормыг 4.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;
- БГД, ХУД-ийн ИХАШШТГ нь анхан шатны баримтгүй 24.1 сая төгрөгийн худалдан авалт хийсэн;
- Багахангай, Налайх дүүргийн шүүхийн Тамгын газар нь ажилтнуудад 8.5 сая төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг үндэслэлгүй олгосон;
- Сэлэнгэ аймаг дахь шүүхийн Тамгын газар нь жолоочийн замын хуудасгүйгээр 2.6 сая төгрөгийн гүйлгээ хийсэн;
- Сэлэнгэ аймаг, Мандал суман дахь сум дундын шүүхийн Тамгын газар нь төрийн үйлчилгээний ажилтнуудад ур чадварын нэмэгдлийг үнэлж дүгнэлгүйгээр 13.3 сая төгрөгийг олгосон;
- БЗД, СБД, ЧД-ийн ЭХАШШТГ нь анхан шатны баримтын бүрдэлгүй 7.1 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 18.7 сая төгрөг болж, өмнөх оноос 12.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага		1.0	0.5	-0.5
Татаас, санхүүжилтийн авлага		0.0	15.0	15.0
Бусад авлага		4.8	3.2	-1.6
Дүн		5.8	18.7	12.9
Үүнээс, байгууллагын төрлөөр	Төсөвт			
байгууллага		5.8	18.7	12.9
Дүн		5.8	18.7	12.9

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдэл өссөн нь татаас санхүүжилтийн авлага 15.0 сая төгрөгөөр өсөж нийт авлагын 80.2 хувийг эзэлж, оны эхний авлага 2.1 сая төгрөгийг барагдуулсан нь нөлөөлсөн байна.

СБД-ийн ЭХАШШТГ-т СБД-ийн ЗД-ын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/405 дугаар захирамжаар шүүхийн үйл ажиллагааг дэмжих хүүхэд, гэр бүл хохирогчийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, саатуулах байрны засварын ажилд зориулж нэмэлт санхүүжилтийн дансанд 15.0 сая төгрөгийн санхүүжилт олгосныг засварын ажлыг гүйцэтгээгүй тул төрийн санд үлдэгдлийг төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэж тайлагнасан байна.

Авлагын үлдэгдэлд 1 жилээс дээш насжилттай 3.7 сая төгрөгийн авлага байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 1,150.2 сая, эцсийн үлдэгдэл 1,386.8 сая төгрөг болж, 236.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн бараа материал		1,142.4	1,381.0	238.6
Мал амьтад		7.8	5.8	-2.0
Дүн		1,150.2	1386.8	236.6
Үүнээс, байгууллагын төрлөөр	Төсөвт			
байгууллага		1,150.2	1,386.8	236.6
Дүн		1,150.2	1,386.8	236.6

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аж ахуй, бусад хангамжийн материал худалдан авалттай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой 45.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Тайлант оны эцэст 28.0 сая төгрөгийн шатах тослох материал, сэлбэг, бараа материалыг нөөцөлж төсвийг хэмнэлтгүй зарцуулсан. /Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба 15.7 сая, Булган аймаг дахь шүүхийн Тамгын газар нь 5.2 сая, Дархан-Уул аймаг дахь давж заалдах шатны шүүхийн Тамгын газар нь 5.8 сая/;
- БЗД-ийн ИХАШШТГ нь 11.7 сая төгрөгийн бараа материалыг тооллогод хамруулаагүй;
- Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШШТГ нь анхан шатны баримтын бүрдэлгүй 6.0 сая төгрөгийн бараа материал зарлагдсан;

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 48,021.7 сая, эцсийн үлдэгдэл 48,867.9 сая төгрөг болж, 846.2 сая төгрөг буюу 1.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 3 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Үндсэн хөрөнгө	48,021.7	48,867.9	846.2
Биет хөрөнгө	43,300.9	44,017.7	716.8
Биет бус хөрөнгө	4,720.8	4,850.2	129.4
Дүн	48,021.7	48,867.9	846.2
Үүнээс, байгууллагын төрлөөр Төсөвт байгууллага	48,021.7	48,867.9	846.2
Дүн	48,021.7	48,867.9	846.2

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2020 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 4-1/1754 тоот шийдвэрийг үндэслэн урсгал төсвийн хөрөнгөөр 776.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, хандиваар 32.6 сая, шилжиж ирсэн 2,047.0 сая, балансаас баланст 672.5 сая, ашиглалтын хугацааг сунгаж 1,188.3 сая, нийт 4,716.6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, ТӨБЗГ-ын шийдвэрийн дагуу акталсан 4069.5 сая, Дархан-Уул аймгийн нутгийн удирдлагын байгууллага болон Шүүхийн тамгын газарт давхар бүртгэлтэй байсан 22.2 сая төгрөгийн орон сууц, нийт 4,091.7 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 261.4 сая төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө ашиглагдаж байна. /Архангай аймаг дахь шүүхийн Тамгын газар 239.6 сая, Дорноговь аймаг дахь шүүхийн Тамгын газар 6.4 сая, Багахангай, Налайх дүүргийн шүүхийн Тамгын газар 15.4 сая/

3.5.5 Өр төлбөр

Тайлант онд богино хугацаат өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 0.4 сая төгрөг болж, өмнөх оноос 0.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	0.9	0.4	-0.5
Дүн	0.9	0.4	-0.5
Үүнээс, байгууллагын төрлөөр Төсөвт байгууллага	0.9	0.4	-0.5
Дүн	0.9	0.4	-0.5

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд үйл ажиллагаатай холбоотой 0.4 сая төгрөгийн өр байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 50,273.0 сая төгрөг болж, өмнөх оноос 1,096.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5 Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл			/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	49,176.8	50,273.0	1,096.2
Дүн	49,176.8	50,273.0	1,096.2
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	49,176.8	50,273.0	1,096.2
Дүн	49,176.8	50,273.0	1,096.2

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,096.2 сая төгрөгөөр өссөн нь Төв аймаг дахь шүүхийн Тамгын газрын балансад өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу 50.0 сая төгрөгийн газрыг шинээр үнэлж бүртгэсэн, мөн тайлант оны үр дүн 1,046.2 сая төгрөг нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагч 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 56,310.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж батлуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан урсгал зардалд 56,310.2 сая төгрөгийн төсвийг баталжээ.

Тайлант онд 56,190.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 120.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжилтийг бүрэн авч, өөрийн үйл ажиллагааны орлогоос 151.7 сая төгрөг, нийт 56,260.5 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлжээ. Үүнээс урсгал зардалд 53,971.9 сая, хөрөнгийн зардалд ТӨБЗГ-ын шийдвэрийн дагуу 776.1 сая төгрөгийг зарцуулж 1,512.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардал 54,748.0 сая төгрөг буюу 97.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 1,562.2 сая төгрөг байгаа нь бараа үйлчилгээний зардлыг 1,518.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь голлон нөлөөлсөн байна.

2020 онд 524 шүүгч ажиллахаар төлөвлөж цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд нийт 44,513.0 сая төгрөгийг төсөвт тусгасан боловч гүйцэтгэлээр 488 шүүгч ажиллаж 36 шүүгчийн орон тоо дутуу ажилласан учир цалингийн зардал 643.0 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын зардал 307.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн.

Мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 86.2 сая, цахим үйлчилгээг нэмэгдүүлснээр бичиг хэргийн зардал 17.5 сая, интернэтийн үйлчилгээг шилэн кабелийн хамт тендер зарлаж шийдвэрлэснээр шуудан холбоо интернэтийн зардал 57.6 сая, Ковид-19 цар тахлын улмаас шүүхийн нүүдлийн хурал хийгдээгүйгээс тээвэр шатахууны зардал 61.2 сая, сургалтын зардал 105.0 сая, эд хогшил, урсгал засварын зардал 139.3 сая, шүүгчийн амь нас эрүүл мэндийн даатгалын тендерийн үр дүнгээр төлөвлөсөн зардлыг 37.5 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Нэмэлт төсөв

Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 147 дугаар тушаалаар давсан орлогоос 245.9 сая, байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 20.5 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан 170.7 сая, нийт 437.1 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс цалин нийгмийн даатгалын зардалд 9.1 сая, хангамж бараа материалын зардалд 20.0 сая, эд хогшил урсгал засварын зардалд 246.8 сая, томилолт зочны зардалд 15.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 53.4 сая, хичээл үйлдвэрлэлийн зардалд 17.0 сая, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 50.0 сая, нийт 411.3 сая төгрөгийг тус тус зарцуулж, 25.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төрийн сан банкны 9 харилцах дансанд 623.5 сая төгрөгийн Эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн захирамжаар иргэд, хуулийн этгээдээс авсан барьцаа хөрөнгийн үлдэгдэл байршиж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэх хэргийн хугацаа харилцан адилгүй байдаг бөгөөд тухайн данснаас шүүгчийн захирамжаар барьцааны мөнгийг олгодог.

Уг барьцааг санхүүгийн тайланд бүртгэх талаар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 7/4338 дугаар албан бичигт УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга, тодруулга” гэсэн стандартаар хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт, хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан үед л санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэнэ гэж тусгасан байна.

Иймд Эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх явцад бусдаас авсан барьцаа нь хөрөнгө, орлого, өр төлбөрийн тодорхойлолт, хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй байгаа тул УСНББОУС-19 “Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө” гэсэн стандартын дагуу тодруулга тайланд тусгах нь зүйтэй гэсэн зөвлөмжийн дагуу Санхүүгийн нэгтгэсэн тайланд бүртгээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Шүүхийн ерөнхий зөвлөл нь 2020 онд нийт 45 зорилтын хүрээнд 91 арга хэмжээ төлөвлөснөөс 78 арга хэмжээ буюу 85.6 хувийг бүрэн хэрэгжүүлж, 8 зорилтын 13 арга хэмжээнээс 3 хэрэгжээгүй, 10 хэрэгжих шатандаа байна гэж дүгнэсэн байна.

Үүнээс цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хамтын ажиллагааны чиглэлээр Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчдийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газруудад танилцуулах Хөгжлийн түншлэгч байгууллагуудын уулзалтыг зохион байгуулах арга хэмжээ хойшлогдсон байна. Цагдаагийн албан хаагчдад зориулсан шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үзүүлэх сургуулилт зохион байгуулах, шүүгчийн хувийн хэрэгт хөтлөх журамд өөрчлөлт оруулах ажил хэрэгжээгүй байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь шилэн дансны цахим хуудсанд 6539 мэдээлэл оруулахаас 6240 мэдээллийг хугацаанд нь, 286 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 13 мэдээллийн хугацаа нь болоогүй байна.

Харьяа байгууллагуудад шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд нь бүрэн байршуулах талаар албан шаардлагыг хүргүүлсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 794.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 21.1 сая төгрөгийн 10 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, 96.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж, 676.8 сая төгрөгийн зөрчилд 42 зөвлөмж өгснөөс 41 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж буюу Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх зөвлөмжийн биелэлт 97.6 хувьтай байна.

Хүснэгт 6. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	10	21.1	10	21.1	100
Албан шаардлага	9	96.9	9	96.9	100
Зөвлөмж	42	676.8	41	676.8	97.6
Нийт дүн	61	794.8	61	794.8	99.2

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

ХУД-т байрлах шүүхийн цогцолбор барилгын суурийн ажил нь хийгдсэн 5,008.5 сая төгрөгийн өртөгтэй дуусаагүй барилгыг 2017 онд Хууль зүй дотоод хэргийн сайдын төсвийн багцаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцад шилжүүлэн авсан байна.

Уг барилгын суурийг хүлээн авснаас хойш хөрөнгө оруулалтын төсөв батлагдаагүй тул барилга угсралтын ажил зогссон байна.

Аудитын явцад тус барилгатай холбогдуулан ХУД дэх цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсээс 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 26/2-2/2065 тоот албан бичгээр тайлбар авсан.

Уг тайлбарт Шүүхийн ерөнхий зөвлөлийн шинэ цогцолбор барилгын ажлын бодит гүйцэтгэлд 1,028.6 сая төгрөгийн зөрүү гарсан байж болзошгүй гэх 2010000189 дугаартай хэрэг үүсгэн шалгагдаж байна. Шалгалтын явцад “Реланс Секьюритиз Аудит” ХХК-иар 2020 онд барилгын гүйцэтгэлд аудит хийлгэн 020/041 дугаартай дүгнэлт гаргуулсан бөгөөд Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн эдийн засгийн шинжээчээр дахин дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн гэсэн байна.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 43 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад итгэл үзүүлж, 3 байгууллага түүвэрт хамрагдаж, 34 байгууллагад дүгнэлт гаргаснаас 1 байгууллагад “Хязгаарлалттай”, 33 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,109.2 сая төгрөгийн 100 алдаа, зөрчил илрүүлснээс 1,471.3 сая төгрөгийн 14 алдааг залруулж, 2.4 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 74.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 7 албан шаардлага хүргүүлэн, 560.9 сая төгрөгийн зөрчилд 64 зөвлөмж өглөө.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 3,267.8 сая төгрөгийн 16 алдаа, зөрчил илрүүлснээс 2,624.1 сая төгрөгийн 8 алдааг залруулж, 643.7 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх 1 албан шаардлага өглөө.

Залруулсан алдаа

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 2,624.1 сая төгрөгийн дараах 6 алдааг залруулав. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд өмнөх оны орлогын гүйцэтгэлийг 2,331.2 сая, зардлын гүйцэтгэлийг 91.5 сая төгрөгөөр тус тус илүү;
- Мөнгөн гүйлгээний тайланд нийт орлого болон зардлын гүйцэтгэлийг 91.5 сая төгрөгөөр тус тус илүү;
- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд өглөгийг 15.0 сая төгрөгөөр зөрүүтэй;
- Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланд урсгал төсвөөс санхүүжих санхүүжилтийн орлогыг 3.4 сая төгрөгөөр зөрүүтэй тус тус тайлагнасан.

Албан шаардлага

Шүүхийн ерөнхий зөвлөл нь шилэн дансны цахим хуудсанд 132 мэдээлэл оруулахаас 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйл 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

Биет хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хөрөнгийн дансанд бүртгэлтэй 267.2 сая төгрөгийн үнэ бүхий элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн авто тээврийн хэрэгслүүдийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байгаа нь ТӨБЗГ-ын 2019 оны 277 дугаар тогтоолын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө, болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж болох сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэх тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлэх”, УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-ийн “Дахин үнэлгээний загвар” хэсэгт дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрт хөрөнгийн бодит үнэ цэнэ, ашиглалтын хугацааг

тооцож үздэг байх. Шаардлагатай бол хөрөнгийг дахин үнэлэх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгүүдийг дахин үнэлүүлэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж, ТӨБЗГ-ын 2019 оны 277 дугаар тогтоолын 7.1 дэх заалтыг мөрдөж ажиллах

2. **Орлого, зардлын данстай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь үндсэн хөрөнгө худалдсаны гарзыг 27.8 сая төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлогыг 58.3 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтлөх, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлогыг тайлант онд хүлээн зөвшөөрч үр дүнгийн тайланд тусгах

3. **Зардлын данстай холбоотой асуудал**

3.1 Илрүүлэлт:

Урсгал засварын зардлаас 1.2 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжид бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлаас 59.4 сая төгрөгөөр биет бус хөрөнгө бэлтгэж зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж байх

4. **Авлага өглөгийн данстай холбоотой асуудал**

4.1 Илрүүлэлт: Авлага өмнөх оноос 12.9 сая төгрөгөөр өссөн, 1 жилээс дээш насжилттай 3.7 сая төгрөгийн авлага бүртгэлтэй, нэр данс зөрүү 3.5 сая төгрөгийн орлогыг өглөг дансанд бүртгэж тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3.”бүх өр төлбөр” заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Авлага өглөгийг барагдуулах, үүссэн авлага өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах.

5. **Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

5.1 Илрүүлэлт: Харьяа шүүхийн тамгын газрууд нь орон нутгийн төсвөөс 213.4 сая төгрөгийн дэмжлэг хүлээн авч хуралдааны танхимын тохижилт болон тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.”, 25.3-т “Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж хандив авч болно”, 25.4.1-д “эх үүсвэр дутагдсан хөтөлбөр арга хэмжээг үргэлжлүүлэх”, 25.4.2-т “байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх”, Шүүхийн тухай хуулийн 42.3.4-т “шүүгчийн

эдийн засгийн болон нийгмийн хангамж, халамжийн тогтолцоог энэ хууль болон бусад хуулиар бүрдүүлэх, хангах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж: Шүүхийн байгууллага дэмжлэг, тусламж авч байгаа нь хараат бус байдал алдагдах эрсдэлийг үүсгэхгүй байх, улсын болон орон нутгийн төсвийг гүйлгэн зарцуулахгүй байхад анхаарах

6. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

6.1 Илрүүлэлт: Тайлант онд төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан бэлтгэж тайлагнаагүй нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан “Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам”-тай нийцүүлэхгүй, санхүүгийн тайлангийн “толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох заавар журмын дагуу үнэн зөв тайлагнаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Д/д	Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр				Нийт зөрчил		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Түүвэрт хамруулсан	Итгэл үзүүлсэн	Үүнээс:		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
				Зөрчилгүй	Хязгаарлалттай								
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ												
1	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	-	-	1	-	6	643.7	-	-	-	-	6	643.7
	ДҮН			1		6	643.8					6	643.7
	ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ												
1	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тамгын газар	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Нийслэл дэх давж заалдах шатны шүүхийн тамгын газар	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Шүүхийн төвлөрсөн төсөв	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба		-	1	-	4	15.8	-	-	-	-	4	15.8
6	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	-	-	1	-	3	48.6	-	-	-	-	3	48.6
7	Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	-	-	1	-	3	19.2	-	-	-	-	3	19.2
8	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	-	-	1	-	4	53.3	-	-	3	32.0	1	21.3
9	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	-	-	1	-	4	43.1	-	-	-	-	4	43.1
10	Баянгол, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	-	-	1	-	3	24.2	-	-	-	-	3	24.2
11	Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	-	-	1	-	3	12.5	1	0.8	-	-	2	11.7
12	Багахангай Налайх дүүргийн шүүхийн тамгын газар	-	-	1	-	6	26.5	-	-	-	-	6	26.5
13	Багануур дүүргийн шүүхийн тамгын газар	-	-	1	-	5	15.5	-	-	2	13.7	3	1.8
14	Архангай аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	2	239.7	-	-	-	-	2	239.7
15	Баян-Өлгий аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	3	16.7	-	-	-	-	3	16.7
16	Баянхонгор аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	3	1.8	-	-	-	-	3	1.8

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

17	Булган аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	4	9.1	-	-	-	-	4	9.1
18	Говь-Алтай аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	4	26.6	-	-	2	0.8	2	25.8
19	Говь-сүмбэр аймаг дахь шүүхийн тамгын газар	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
20	Дархан-Уул аймаг дахь давж заалдах шатны шүүхийн тамгын газар	-	-	1	-	4	7.4	-	-	1	-	3	7.4
21	Дархан-Уул аймаг дахь анхан шатны шүүхийн тамгын газар	-	-	1	-	3	20.8	-	-	1	5.4	2	15.4
22	Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	2	8.7	-	-	1	2.3	1	6.4
23	Дорноговь аймаг Замын-Үүд суман дахь сум дундын шүүхийн тамгын газар	-	-	1	-	1	-	-	-	-	-	1	-
24	Дорнод аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	1	0.3	-	-	-	-	1	0.3
25	Дундговь аймаг дахь шүүхийн тамгын газар	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
26	Завхан аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
27	Завхан аймгийн Тосонцэнгэл суман дахь сум дундын шүүхийн тамгын газар	-	-	-	1	3	12.8	1	0.7	-	-	2	12.1
28	Орхон аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	2	4.1	-	-	-	-	2	4.1
29	Өвөрхангай аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
30	Өвөрхангай аймгийн Хар хорин суман дахь сум дундын шүүхийн тамгын газар	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
31	Өмнөговь аймаг дахь шүүхийн тамгын газар	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
32	Өмнөговь аймгийн Ханбогд суман дахь сум дундын шүүхийн тамгын газар	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
33	Сүхбаатар аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	1	0.9	1	0.9	-	-	-	-
34	Сэлэнгэ аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	5	7	-	-	3	6.2	2	0.8
35	Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь сум дундын шүүхийн тамгын газар	-	-	1	-	5	14.2	-	-	2	14.2	3	-
36	Сэлэнгэ аймгийн Сайхан суман дахь сум дундын шүүхийн тамгын газар	-	-	1	-	2	1.4	-	-	-	-	2	1.4
37	Төв аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	2	7.7	-	-	-	-	2	7.7
38	Увс аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
39	Ховд аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
40	Ховд аймгийн Булган суман дахь сум дундын шүүхийн тамгын газар	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
41	Хөвсгөл аймаг дахь шүүхийн тамгын газар	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
42	Хэнтий аймаг дахь шүүхийн тамгын газар	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
43	Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь сум дундын шүүхийн тамгын газар	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
	ДҮН	4	6	32	1	72	637.9	3	2.4	7	74.6	62	560.9
	НИЙТ ДҮН	4	6	33	1	80	1,281.6	3	2.4	7	74.6	70	1,204.6

6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

/сая төгрөг/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Ажилтанд үр дүнгийн урамшуулал илүү тооцож олгосон	0.7	Акт	Тамгын газрын дарга, Нягтлан бодогч	Б.Өлзий, Г.Баатармаа
2	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү тооцож олгосон	0.9	Акт	Тамгын газрын дарга Нягтлан бодогч	Ц.Ганхуяг Г.Наранцэцэг
3	Ажилтны цалингаас ХХОАТ зөрүүтэй тооцож суутгасан	0.8	Акт	Тамгын газрын дарга Нягтлан бодогч	Ц.Амартөгс О.Марина
4	Цалингийн зардлаас НДШ төлсөн, Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	0.8	Албан шаардлага	Тамгын газрын дарга, Нягтлан бодогч	Ж.Ганболд, Э.Баярмагнай
5	Нэр бүхий ажилтнуудад тайлант оны төсвийн хэмнэлтээс урамшуулал олгосон.	5.4	Албан шаардлага	Тамгын газрын дарга, Нягтлан бодогч	Б.Бат-Амгалан, Б.Болормаа
6	Эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан.	2.3	Албан шаардлага	Тамгын газрын дарга, Нягтлан бодогч	Т.Даваадорж, А.Одонтуяа
7	Ээлжийн амралттай ажилтанд 3.0 сая төгрөгийн цалин давхардуулан олгосон, аймгийн Онцгой комисст 0.5 сая төгрөгийн хандив олгосон, жолоочийн тооцооны хуудасгүйгээр 2.7 сая төгрөг зарцуулсан.	6.2	Албан шаардлага	Тамгын газрын дарга, Нягтлан бодогч	М.Нямсүрэн, Л.Одонтуяа
8	Зардлын бүлэг хооронд 0.4 сая төгрөг шилжүүлэн зарцуулсан, 0.4 сая төгрөгийг гэрээний гүйцэтгэл болон ажил хүлээн авсан актгүйгээр олгосон. Төрийн үйлчилгээний ажилтнуудад үндэслэлгүй 13.3 сая төгрөгийн нэмэгдэл олгосон.	14.2	Албан шаардлага	Тамгын газрын дарга, Нягтлан бодогч	Д.Батсайхан, Н.Сансугар
9	Анхан шатны баримтгүй 7.1 сая төгрөгийн гүйлгээ хийсэн, тооцоо нийлсэн актгүй 15.0 сая төгрөгийн өглөг бүртгэсэн, 1 төрлийн бүтээгдэхүүний төсөвт ертгийг тендер зохион байгуулаагүй, хувааж худалдан авалт хийж	32.0	Албан шаардлага	Тамгын газрын дарга, Нягтлан бодогч	Г.Болормаа, М.Мөнх-Эрдэнэ
10	Ажлын үр дүнг дүгнээгүй 13.7 сая төгрөгийн урамшуулал олгосон.	13.7	Албан шаардлага	Тамгын газрын дарга, Нягтлан бодогч	Б.Эрдэнэбаяр, Э.Давааням
	ДҮН	77.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 579/АОН0001

Улаанбаатар хот

СДТ-2021/0/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд ил тод, иж бүрэн байршуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Э.Батбаяр, Ерөнхий нягтлан бодогч, референт С.Наранбилэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ